

БАТЛАВ.


ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ ХАМГААЛАХ
ХАМГААЛАХ ТӨВИЙН ХИРЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



У.ДАВААЖАВ

БАТЛАВ

“БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭДЭЭЛЭЛ
СУРГАЛТЫН ТӨВ” НҮТББ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



О.ШИНЭЦЭЦЭГ

“УСНЫ ҮНЭ ЦЭН, ҮНЭЛЭМЖ”

НИЙТЛЭЛ БИЧИХ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

№ 2021/04

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Дэлхийн нийт усны нөөцийн 2.5%-ийг цэвэр ус юм. Цэнгэг усны нөөцийн дийлэнх хувийг өмнөд, хойд туйлын мөс цас, мөсөн голууд эзэлдэг. 2020 оны байдлаар дэлхий даяар хүний хэрэгцээнд зориулан 4600 гаруй шоо километр ус олборлож буйгаас 69 хувийг нь хөдөө аж ахуй, газар тариалангийн усалгаанд, 19 хувийг нь аж үйлдвэрлэл, 12 орчим хувийг нь хотын хүн амын унд, ахуйн хэрэгцээнд ашиглаж байна.

Хүн амын хурдтай өсөлт, уур амьсгалын өөрчлөлт, хотжилт зэрэг олон хүчин зүйлийн нөлөөгөөр усны хэрэглээ жил бүр эрчимтэй нэмэгдэж байна. 2050 гэхэд дэлхийн хүн амын тоо 9.8 тэрбумд хүрч, усны хэрэглээ одоогийн хэрэглээнээс 20-30 хувиар нэмэгдэх тооцоо гарсан байна.

Түүнчлэн хотжилт эрчимтэй явагдсанаар цэвэр усны хүртээмжийн тэнцвэр алдагдаж, хүн ам болон цэвэр усны нөөцийн жигд биш тархалттай холбоотойгоор ойрын хэдэн арван жилийн хугацаанд дэлхийн олон улс оронд цэвэр усны нөөцийн хомсдолд ороод байна.

Дэлхий даяараа усны нөөцөө үр ашигтайгаар удирдах зохистой хэрэглээг бий болгох асуудал тулгараад байна. Иймд усны үнэ цэн, усны хэрэглээний талаар олон нийтэд сурталчлах, усны үнэ цэнийг ойлгуулах чухал хэрэгцээ шаардлага дэлхий нийтийн өмнө тулгараад байна. Ус бидний амьдралд янз бүрийн байдлаар ашиг тусаа өгдөг бид усыг зохих ёсоор нь үнэлж, хүн бүр үр дүнтэй хэрэглээ ашиглалтыг бий болгосноор усны нөөцийг хамгаалж чадна.

ХОЁР. ЗОРИЛГО

Бидний өдөр тутамдаа хэрэглэдэг усны хэрэглээ, түүний зүй зохистой ашиглалтын талаарх хүүхэд багачуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, тэднийг өөрийн үзэл бодлоо илэрхийлж усны үнэ цэн, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлан таниулахад дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ

Ерөнхий боловсролын сургуулийн 15-18 насны сурагчдын дунд зохион байгуулна.

Сэдвийн хүрээ:

- Амьдралын сайн сайхан байдал- Усны үнэ цэн
- Эрүүл мэнд - Эрүүл, аюулгүй ундны усны үнэ цэн
- Байгаль дахь усны эргэлт -Усны үнэ цэн
- Оюун санааны хүч – Усны үнэ цэн

ДӨРӨВ. БҮТЭЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Ерөнхий шаардлага	1. Үгийн тоо /700-750 үгтэй/
	2. Нийтлэлд 140 тэмдэгтэд багтаан нэр өгөх;
	3. Бичгийн стандарт /MS OFFICE, үсгийн фонт–ариал 11, мөр хоорондын зай 1.5, цаасны дээд захаас 20 мм, доод захаас 20 мм, зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм, PDF хэлбэрт хөрвүүлсэн байх;
	4. 1-2 зураг (гэрэл зураг, зураг чимэглэл, диаграмм гэх мэт) тус бүрдээ 20-оос ихгүй үг бүхий тайлбартай байх./ Ашигласан зургийн эх сурвалжийг дурьдах;
	5. Бүтцийн хувьд оршил, үндсэн хэсэг, дүгнэлт хэсэг бүхий Хэн? Юуг? Хаана? Яагаад? Хэзээ? Яаж? гэсэн асуултад хариулагдахаар бичсэн байх;
	6. Уралдаанд оролцож байгаа сурагчид нь овог нэр, нас, хүйс, регистрийн дугаар, аймаг /хот/, сум, холбоо барих утасны дугаар, имэйл хаягаа нийтлэлийн төгсгөлд алдаагүй бичиж бх9 хэмжээтэй өнгөт цээж зургийн хамт зарласан хугацаанд нийтлэлтэйгээ хамт ирүүлэх
	7. Уралдаанд ирүүлсэн нийтлэл зохион байгуулагчдын сан хөмрөгт зохиогчийн эрхтэйгээр үлдэнэ. Мөн оролцогчдын бүтээлийг сонин хэвлэл, цахим сүлжээнд нийтлэх, сурталчилгааны ажилд ашиглах эрхийг уралдаан зохион байгуулагчид байгууллагуудад зөвшөөрнө.
	8. Уралдаанд нэг хүн нэг бүтээлээр оролцох боломжтой
Агуулгын шаардлага	1. Сэдвийн нэр, агуулгад нийцсэн байх;
	2. Усны үнэ цэнийг тодорхойлсон байдал
	3. Усны үнэ цэнийг хөндсөн, усаа зүй зохистой ашиглах хэвшлийг бий болгохыг уриалсан сэдвүүдийг хөндсөн байдал
	4. Бүтээлч хандлага, үндэслэлтэй тоо баримт, жишээнд тулгуурласан байх;
	5. Өөрийн байр сууриа тодорхой, ойлгомжтой илэрхийлсэн байх;
	6. Монгол хэлний дүрмийн болон утга найруулга, логикийн алдаагүй байх;
	7. Нийтлэлийн төгсгөлд ашигласан ном, зохиол, ишлэл авсан эх сурвалжийг оруулсан байх.

	8. Асуудалд тэнцвэртэй бодитой хандсан байх;
	9. Дэвшүүлсэн асуудлыг тал бүрээс нь авч үзсэн байх
	10. Нийтлэл нь баримт судалгаанд тулгуурласан, тэнцвэртэй, олны анхаарлыг татаж, нийгмийн сэтгэлзүйд хүрэхүйц, мэдээллийн эх сурвалжаа тодорхой дурдсан, асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлж санал болгосон байвал зохино.
Түгээсэн байдал	1. Нийтлэлээ өөрийн хувийн цахим сүлжээгээр олон нийтэд түгээсэн байх бөгөөд олон нийтэд түгээснийг нотлох баримтыг нийтлэлийн хамт илгээнэ.

ТАВ. УРАЛДААНЫГ ДҮГНЭХ, ШАЛГАРУУЛАХ

Уралдааны бүтээлийг 2021 оны 04 дүгээр сарын 09-ний 17:00 цаг хүртэл yremongolia@gmail.com хаягаар хүлээн авна.

Уралдаанд ирүүлсэн бүтээлийн агуулгын болон хэлбэрийн шаардлага хангасан эсэхийг тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу уралдаан зохион байгуулах ажлын хэсэг дүгнэж, шалгаруулах бөгөөд уралдаан 2 үе шаттай зохион байгуулагдана. Үүнд:

I шат - Оролцогчдын бүтээлийг **2021 оны 04 дүгээр сарын 10-наас 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл цахим сүлжээнд байршуулж**, цахим хандалт болон шүүгчдийн саналыг үндэслэн эхний 10 бүтээлийг шалгаруулна.

II шат- Мэргэжлийн сэтгүүлчид болон зохион байгуулагчдын төлөөллийг багтаасан шүүгчдийн бүрэлдэхүүн **2021 оны 04 дүгээр сарын 16-ны** дотор эцсийн шалгаруулалтыг хийнэ.

- Шүүгчид ирүүлсэн бүтээлийн утга санаа, уран сэтгэмж, өгүүлэмж, тайлбар, чанар, бүтээлийн агуулга ба нэр, тэдгээрийн шүтэлцээ зэргийг үндэслэн доорх байдлаар 0-5 оноогоор дүгнэнэ. Үүнд:

- 5 оноо = Онц сайн
- 4 оноо = Маш сайн
- 3 оноо = Сайн
- 2 оноо = Дунд зэрэг
- 1 оноо = Шаардлага хангасан
- 0 оноо = Шаардлага хангаагүй

Уралдаанд бүтээлээ ирүүлсэн оролцогчид шүүгч тус бүрээс ямар ч үнэлгээ авах магадлалтай бөгөөд шалгуур үзүүлэлтүүдийг хангасан оролцогч байр эзэлнэ.

- ❖ Тэргүүн байранд шалгарсан нэг нийтлэлийг олон Дэлхийн байгаль орчны боловсролын сан (FEE)-ийн “Байгаль орчны залуу сурвалжлагч” олон улсын уралдаанд оролцуулна. Мөн өдөр тутмын сонинд нийтэлнэ.

ЗУРГАА. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

1-р Байр - 1 (500,000) таван зуун мянган төгрөг, өргөмжлөл

2-р байр - 2 (300,000) гурван зуун мянган төгрөг, өргөмжлөл

3-р байр – 3 (200,000) хоёр зуун мянган төгрөг, өргөмжлөл

Тусгай байр – 4 (100,000) зуун мянган төгрөг, өргөмжлөл

ДОЛОО. ХҮРЭХ ҮР ДҮН

- Усны үнэ цэн, ач холбогдлын талаар хүүхэд багачуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, тэдний үзэл бодлыг нийтлэлээр дамжуулан олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах;
- Хүүхэд, залуусын авьяас чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх,
- Усыг үнэлэх, усны нөөцийг хамгаалах үйлсэд хүүхэд залуусын оролцоог нэмэгдүүлэх, хүүхэд залуусын үзэл санаагаар дамжуулан олон нийтэд нөлөөлөх;

НАЙМ. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

- “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” УТҮГ
- “Байгаль орчны мэдээлэл, сургалтын төв” ТББ

ЕС. ХОЛБОО БАРИХ

Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Зайсан 9, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв. Утас: 99153165, 99085775, 92050506

--- оОо ---